



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

МОНГОЛЫН ТАТВАРЫН АГВАА



info@mta.gov.mn



+976-11-314155, 318793



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, С.Данзангийн гудамж 4-А

АГУУЛГА

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН	2
Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	2
1.1 Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэр Ерөнхий сайдын захирамж, шийдвэрийн биелэлт	3
1.2 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичгийн биелэлт /Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого/	3
1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	4
1.4. Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	4
1.5. Улсын төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт.....	5
Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ.....	5
2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас агентлагийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	6
2.2 Агентлагийн тухайн оны төсвийн гүйцэтгэл.....	6
2.3 Агентлагийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:	7
2.4 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны хэрэгжилт	8
2.5 Аудит, хяналт-шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт	8
2.6 Шилэн дансны хөтлөлт.....	11
Гурав. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний тайлан.....	12
Дөрөв. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	12
4.1 Агентлагийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт	13
4.2 Хэрэглэгчийн үнэлгээний тайлан	13

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилт

Дээд газрын бодлого, зорилтын хүрээнд 2021 оны эхний хагас жилд агентлагийн хэмжээнд хэрэгжүүлсэн зорилт, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Татварын албаны 2021 оны үндсэн чиглэл болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд нь үр дүнд хүрсэн эсэх, татварын албаны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн менежментийг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл, зөвлөмжөөр хангахад чиглэгдсэн болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Татварын ерөнхий газрын 2021 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалаар баталсан “Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”, Татварын ерөнхий газрын даргын 2020 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Татварын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-аар тодорхойлсон арга зүйн хүрээнд гүйцэтгэлээ.

Хамарсан хүрээ

Агентлагийн 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, хүрсэн үр дүнг мэдээ, тайлан, судалгаа, баримт материалд тулгуурлан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээг үзүүлэлт тус бүрээр танилцуулж тайланг бэлтгэлээ.

- Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ
- Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ
- Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТ		Үнэлгээнд авах оноо	Хувь	Оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	10	97.11	9.71
2	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	40	96.47	38.45
3	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	5	96.86	4.84
4	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	45	92.02	41.71
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ		100	94.72	94.72

Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд журам, аргачлалаар тодорхойлсон дараах 3 үзүүлэлтүүдийг авч үзлээ. Үүнд:

Д/Д	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Үнэлгээ	Оноо
1.1	Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, шийдвэрийн биелэлт	96.67	1.93

1.2	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичгийн биелэлт /“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”/	100.0	2.00
1.3	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	100.0	2.00
1.4	Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	100.0	2.00
1.5	Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт	90.00	1.80
Үнэлгээний нийт оноо		97.33	5.87

1.1 Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэр Ерөнхий сайдын захирамж, шийдвэрийн биелэлт

Тайлант хугацаанд татварын албаны хэмжээнд дээд газрын 34 тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **96.67** хувиар үнэлэгдэж байна. Хяналтад авсан шийдвэрийн нэгтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна./Хавсралт-1, дэлгэрэнгүй/

Д/Д	Дээд газрын тогтоол, шийдвэр, үүрэг даалгавар	Шийдвэрийн тоо	Үнэлгээ	
			Хувь	Оноо
1.1.1	Ерөнхийлөгчийн зарлиг	1	100.00	2.00
1.1.2	Засгийн газрын тогтоол	21	93.75	1.88
1.1.3	Ерөнхий сайдын захирамж	1	100.00	2.00
1.1.4	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	11	92.92	1.86
Нийт дүн		34	96.67	1.93

Тайлант хугацаанд дээд газрын тогтоол, шийдвэр 34 ирсэн. 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр “Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор зохион байгуулах махны өргөтгөсөн худалдаанд эрүүл бүсээс гарал үүслийн гэрчилгээтэй махыг нийслэлийн заасан байршилд худалдан борлуулах, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай” гэсэн үүрэг даалгаврыг Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 58 дугаар тэмдэглэлтэй нэгтгэн дүгнэсэн тул үнэлээгүй болно. ТЕГ-т ирсэн хууль тогтоомж, шийдвэрийн 2021 оны хэрэгжилтийг 2021 оны 03/2910 дугаар албан бичгээр Сангийн яамны ТЗУГ-т хүргүүлсэн.

1.2 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичгийн биелэлт /Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого/

Монгол Улсын Их хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Мөн тус тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталсан. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Сангийн сайдын дангаар болон бусад яамдтай хамтран хэрэгжүүлэх 1 арга хэмжээ тусгагдсан байна. Үүнд:

Хотын татварыг төрөлжүүлэн, онцгой албан татвар бий болгох; /“АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 9.4. “Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно”, 4 дэх заалт/ **Хэрэгжилт:** Нийслэл хотын албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд тулгарч байгаа асуудалд үндэслэн, олон улсын туршлага судалж, Хотын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үүнтэй холбогдуулан боловсруулсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Татварын ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга, саналыг Сангийн яаманд 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/1438 дугаар албан бичгээр хүргүүлсэн. **Үр дүн:** Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль УИХ-р хэлэлцэгдэн 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсантай холбогдуулан дагалдах хууль

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлан 2021 он

буюу Нийслэл хотын албан татварын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Дээрх хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд "Албан татвар ногдох авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, бүртгэлээс хасах журам" батлах тухай Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалын төсөл, "Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн ерөнхий журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Сангийн сайдын тушаалын төслийг боловсруулж, Сангийн яаманд 2021 оны 01/2368 дугаар албан бичгээр хүргүүлсэн. /Хавсралт-2/

Үнэлгээ: 100.0

1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Сангийн яамны хэрэгжүүлэх арга хэмжээнд татварын албаны үйл ажиллагаатай холбоотой 6 арга хэмжээ тусгагдсаныг Татварын ерөнхий газрын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг тухай бүр ханган ажилласан ба агентлагийн хэмжээнд **100.0** хувиар үнэлэгдэж байна.

Д/д	Арга хэмжээний тоо	Үнэлгээ	
		хувь	Оноо
1	6	100	2.0
Нийт үнэлгээ		100.0	2.0

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг 2021 оны 03/2646 дугаар албан бичгээр Сангийн яамны ТЗУГ-т хүргүүлсэн. /Хавсралт-3/

“Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” тогтоолоор баталсан Сангийн яамны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд татварын албаны үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээ тусгагдаагүй болно.

1.4. Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлт

Тайлант хугацаанд Татварын албанд Сангийн сайдын 3 тушаал ирснийг бүртгэн, хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Д/д	Өгсөн үүрэг шийдвэрийн тоо	Үнэлгээ	
		Хувь	Оноо
1	3	100.0	2.0
Нийт үнэлгээ		100.0	2.0

Хэрэгжилтийг Сангийн сайдаас өгсөн тушаал бүрээр танилцуулбал: Үүнд:

2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 07 дугаар тушаал

Татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.044 хувь, татварын албанаас үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.036 хувь байхаар тогтоож, 2021 оны татварын жилд мөрдсүгэй.

Хэрэгжилт: Сангийн сайдын баталсан тушаалаар татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг мөрдөх хугацаа нь татвар төлөгчийн 2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийснээр хэрэгжих ба тайлант хугацаанд зөвхөн татвар төлөгчийн хүсэлтээр татан буугдаж байгаа 287 татвар төлөгчид татварын хяналт шалгалт хийсэн. Монгол Улсын Их хурлын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Татварын алданги торгуулиас чөлөөлөх тухай” хуульд заасны дагуу дээрх татвар төлөгчдөд ТЕХ-ийн 73 дахь заалтаар алданги тооцоогүй.

Үнэлгээ: 100.0

2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тушаал

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, уг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бүртгэл хөтлөх, хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хэрэгжилт: Тайлант хугацаанд Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу 52'007 татвар төлөгч илүү төлсөн албан татвар буцаан авах хүсэлтийг цахимаар ирүүлсэн ба хүсэлтэд хяналт

тавьснаар 51'870 иргэнд 29.9 тэрбум төгрөгийн буцаан олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэн, ТУНС-д бүртгэлийг хөтөлж ажилласан.

Үнэлгээ: 100.0

2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тушаал

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу албан татвар төлөгчийн илүү төлсөн албан татварыг буцаан олгох, буцаан олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бүртгэл хөтлөх, нягтлан бодох бүртгэлд тусгах, буцаан олголтын хяналтыг хэрэгжүүлэх харилцааг энэ журмаар зохицуулна.

Хэрэгжилт: ААНОАТ-ын буцаан олголтыг цахимаар хүсэлт хүлээн авах, ТУНС-ээр гүйлгээг Төрийн санд шилжүүлэх нэвтрүүлэлтийг бүрэн хийснээр нийт 856 татвар төлөгчийн 8.5 тэрбум төгрөгийн буцаан олголтыг баталгаажуулан, олгосон. Мөн бусад татварын өрд 274 татвар төлөгчийн 1.7 тэрбум төгрөгийг суутган тооцсон.

Үнэлгээ: 100.0

1.5. Улсын төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт

Татварын албаны хэмжээнд 2021 онд улсын төсөв, гадаадын зээл тусламжаар 3 төсөл, 1 хөтөлбөр хэрэгжиж байна. Дээрх төсөл, хөтөлбөрт татварын албанаас 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэрэгжилтэд ХШҮ хийхэд 90.00 оноогоор “Маш сайн” гэж үнэлэгдэж байна. Төсөл, хөтөлбөрт хийсэн үнэлгээг танилцуулбал дараахь байдалтай байна.

Д/д	Төсөл, хөтөлбөрийн нэр	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Хувь	Оноо
1	“Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх нь”	6	91.67	1.84
2	Татварын шинэ хуулийн хэрэгжилтийг хангах татварын албаны чадавхийг бэхжүүлэх	13	91.67	1.84
3	Татварын бодлого, татвар төлөгчдийн хууль тогтоомж мөрдөлтийг сайжруулах төслийн үнэлгээ	182	81.66	1.63
4	Хил хязгааргүй татварын байцаагч хөтөлбөрийн үнэлгээ	5	95.00	1.90
Дундаж үнэлгээ		206	90.00	1.80

Татварын албаны хэмжээнд 2021 онд улсын төсөв, гадаадын зээл тусламжаар 3 төсөл, 1 хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний тайланг хавсаргав.

Үнэлгээ: 90.00

Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээнд 6 үзүүлэлтүүдийг авч үзлээ. Үүнд:

Д/д	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Үнэлгээ	Оноо
2.1	Төсвийн ерөнхийлөн захирагчаас агентлагийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	95.10	14.27
2.2	Агентлагийн тухайн оны төсвийн гүйцэтгэл	94.00	4.70
2.3	Агентлагийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	100.00	5.00
2.4	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны хэрэгжилт	97.35	4.87
2.5	Аудит, хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт	95.00	4.75
2.6	Шилэн дансны хөтлөлт	97.35	4.87
Үнэлгээний нийт оноо		96.47	38.45

2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчаас агентлагийн ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 04 дүгээр хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний загварын хүрээнд “ТЕГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулахаар 2021 оны 01/592 дугаар албан бичгээр Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн. Тус төлөвлөгөөнд “ТАТВАРЫН БОЛОВСРОЛЫН ЖИЛ” зорилтын хүрээнд 8, “ХУУЛЬ ТОГТООМЖ, ЧИГ ҮҮРЭГ”-ийн зорилтын хүрээнд 50, нийт 5 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг тусгасан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд харьцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **95.10** хувиар үнэлэгдэж байна./ Хавсралт-5/

Зорилт	Арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн	Үнэлээгүй ажил	Нийт Үнэлгээ
Татварын боловсролын жил зорилт	8	8	-	95.00
Хууль тогтоомж, чиг үүргийн зорилт	50	49	1	95.20
Нийт	58	57	1	95.10

Үнэлгээ: 95.10**2.2 Агентлагийн тухайн оны төсвийн гүйцэтгэл**

Агентлагын тухайн оны төсвийн гүйцэтгэлийн үнэлгээнд 3 үзүүлэлтүүдийг авч үзлээ. Үүнд:

Д/Д	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Үнэлгээ	Оноо
2.2.1	Төсвийн гүйцэтгэл	97.00	4.85
2.2.2	Өглөг авлага	90.00	4.50
2.2.3	Орон тоо, цалингийн сан	95.00	4.75
Үнэлгээний нийт оноо		94.00	4.70

Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Татварын албаны хэмжээнд 2021 онд батлагдсан 59,718.1 сая төгрөгийн төсвөөс 56,868.3 сая төгрөгийн төсвийг харьяа татварын албадуудад хуваарилж, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан.

Татварын Ерөнхий Газрын 2021 оны нийт урсгал зардал 56,868.3 сая төгрөгийг төлөвлөснөөс улсын төсвийн санхүүжилтээр 56,170.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,667.8 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 137.1 сая төгрөгийн эх үүсвэрээс зарцуулахаар төсөвлөсөн байна.

2021 оны байдлаар улсын төсвөөс 56,708.1 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 2,890.0 сая төгрөг, туслах үйл ажиллагаанаас 120.0 сая төгрөгийн орлогыг тус тус олж нийт 59,718.1 сая төгрөгийн төсвийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Хөрөнгө оруулалтаар 12,960.5 сая төгрөг байхаар батлагдсанаас 12,422.34 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд татварын албаны албан хаагчдын цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 28,698.4, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3,817.9, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,597.4, хангамж бараа материалын зардалд 1,237.8, норматив зардалд 234.0, эд хогшил, урсгал засварын зардалд 271.7, томилолт, зочны зардалд 148.3, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 6,224.3, бараа үйлчилгээний бусад зардалд 289.8, бусад урсгал шилжүүлэгт 1,926.3 сая төгрөг нийт 42,519.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Үнэлгээ: 97.0**Өглөг, авлагын талаар:**

2021 оны эхний авлага 579.7 сая төгрөг байснаас 612.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,110.0 сая төгрөгөөр хорогдож 2021 оны эцсийн байдлаар 81.9 сая төгрөг байна.

2021 оны эцсийн байдлаар тайлант хугацаанд ТЕГ нь Сангийн Яамнаас авах авлага 198.5 сая төгрөг, бусад байгууллагаас авах авлагыг ТЕГ, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг, Баян-Өлгий,

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлан 2021 он

Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймгийн татварын албад нь 412.3 сая төгрөг, Багануур дүүрэг, Увс аймгийн татварын албад нь хувь хүмүүсээс авах авлагыг 1.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. ТЕГ нь Сангийн Яамнаас авах авлагыг 198.5 сая төгрөг, бусад байгууллагаас авах авлагыг 909.9 сая төгрөгөөр, Багануур, Багахангай, Хан-Уул дүүрэг, Увс аймгийн татварын хэлтэс нь хувь хүний орлогын албан татварын 1.5 сая төгрөг, ТЕГ, Багануур дүүрэг нь бусад байгууллагаас авах авлага 894.5 сая төгрөг, Архангай аймгийн татварын хэлтэс нь Сэргээн босголт банкнаас авах авлагыг 0.6 сая төгрөг, Багахангай дүүргийн татварын хэлтэс нь хувь хүмүүсээс авах 0.17 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулсан байна.

2021 оны эхний өглөг 5.8 сая төгрөг байснаас 2021 оны эцсийн байдлаар 1,269.0 сая төгрөгийн өглөг нэмэгдэж, 683.7 сая төгрөгийн өр барагдаж тайлант хугацааны эцэст 591.1 сая төгрөг байна. 2021 оны эцсийн байдлаар Баянзүрх дүүрэг, Баянхонгор, Увс, Хөвсгөл аймгийн татварын хэлтсийн барилгын барьцаа 483.1 сая төгрөг, бусад байгууллагад 108.0 сая төгрөг өглөгтэй гарсан байна.

Үнэлгээ: 90.0

Орон тоо, цалингийн сангийн талаар:

2021 оны эцсийн байдлаар цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 30,631.4 сая төгрөг зарцуулах төсөвтэйгөөс төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 28,698.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Үнэлгээ: 95.0

2.3 Агентлагийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт:

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад ТЕГ-ын 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг оруулж, төсөл арга хэмжээний жагсаалтад худалдан авах ажиллагааг нэг бүрчлэн оруулан, дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулснаас 2021 онд улсын төсвөөс санхүүжих дүн 15,920.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд урсгал төсвөөр 8 төсөл арга хэмжээг 11,152.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Татварын албаны хөрөнгө оруулалтын төсвөөр хийх худалдан авах үйл ажиллагаа

/мянган төгрөг/

д/д	Барилга байгууламж	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэмнэлт
1	Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн барилга угсралтын ажил	2,140,000.0	2,030,983.0	109,016.8
2	Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн барилга угсралтын ажил	2,140,900.0	1,898,284.9	242,615.1
3	Увс аймгийн Татварын хэлтсийн барилга угсралтын ажил	2,140,000.0	2,043,923.6	96,076.4
4	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн барилга	9,500,000.0	5,179,432.6	
Нийт дүн		15,920,900.0	11,152,624.3	447,708.3

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн барилга угсралтын ажлыг “Хашгоёо” ХХК барилга угсралтын ажил нь 100 хувийн гүйцэтгэлтэй явагдаж дуусан улсын комисс ажиллаж, аудитаар баталгаажуулж хүлээлгэн өгсөн.

2021 оны худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан шилжих барилга байгууламжид:

Хөвсгөл аймгийн татварын хэлтсийн барилгын ажлыг гүйцэтгэж буй “Их үен” ХХК барилга угсралтын ажил нь 100 хувийн гүйцэтгэлтэй явагдаж дуусан улсын комисс ажиллаж, аудитаар баталгаажуулж хүлээлгэн өгсөн.

Увс аймгийн татварын хэлтсийн барилгын ажлыг гүйцэтгэж буй “Мана оюу Увс” ХХК барилга угсралтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн барилгыг 2021 оны 10-р сарын 22-ны өдрийн 34/2021 дугаар дүгнэлтийн дагуу улсын комисст хүлээлгэн өгсөн.

Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн байрны барилга угсралтын ажлыг “Бумбод” ХХК гүйцэтгэж барилга угсралтын ажил 50 хувийн гүйцэтгэлтэй ба хүйтний улирал эхэлсэн тул ажлыг түр зогсоож гэрээний хугацааг 2022 оны 10 дугаар сарын 01 хүртэл сунгаж 9,480.0 сая төгрөгийн гэрээ байгуулан 2021 онд 4,094.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн үлдэгдэл 4,300.5 сая төгрөг СЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд байна.

д/д	Барилга байгууламжийн их засварын ажил	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэмнэлт
1	Татварын ерөнхий газрын байрны засварын ажил	998,000.0	964,942.5	112,951.6

Татварын ерөнхий газрын барилгын засварын ажлыг 2020 онд цахим тендер шалгаруулах журмын дагуу зохин байгуулсан бөгөөд тендэрт оролцсон “Содон номин констракшин” ХХК он дамнаж засварын ажил хийгдсэн байна.

Татварын албаны 2021 онд урсгал төсвөөр хийх худалдан авах үйл ажиллагаа

Улсын төсвийн урсгал төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих 428.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд урсгал төсвөөр 3 төсөл арга хэмжээг 403.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 24.9 сая төгрөгийн хэмнэлттэйгээр ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг бүрэн зохин байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Вирусны програм худалдан авах	85,000.0	81,730.0
2	Windows үйлдлийн системийн лиценз нийлүүлэх	101,250.0	83,842.0
3	Татварын тайлан шинжилгээнд зориулсан программ хангамж лиценз нийлүүлэх суурилуулах	242,550.0	238,279.6
Нийт дүн		428,800.0	403,851.6

Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой 3 тендер зарлагдсанаас Вирусны программ худалдан авах тендерт оролцсон “Инфосолюшин” ХХК, Windows үйлдлийн системийн лиценз нийлүүлэх тендерт оролцсон “Мобинет” ХХК, Татварын тайлан шинжилгээнд зориулсан программ хангамж лиценз нийлүүлэх суурилуулах тендерт оролцсон “Ай Ти Зоне” ХХК-иуд шалгарсан оролцогч нараас ямар нэгэн гомдол маргаан үүсээгүй болно. Нийт 3 худалдан авах ажиллагаа зохион байгуулж 24.9 сая төгрөгийн төсвийн хэмнэлт хийсэн байна.

Үнэлгээ: 100.0

2.4 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралт “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт”-ийг хангах зорилгоор татварын албаны хэмжээнд төрийн албан хаагчийн нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны ажлын биелэлт, үнэлгээ дараах байдалтай байна. Үүнд:

Д/Д	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо тоо	Үнэлгээ	
			Хувь	Оноо
1	Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	9	99.45	4.97
2	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	6	95.27	4.76
Нийт дүн		15	97.35	4.87

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн **15 шалгуур үзүүлэлт**ээр үнэлгээ хийсэн. /Хавсралт-6/ **Үнэлгээ: 97.35**

2.5 Аудит, хяналт-шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт

Төрийн аудитын газраас Татварын ерөнхий газрын үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн аудит, Нийслэлийн төрийн аудитын газраас 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 727 дугаар албан бичгээр ирүүлсэн Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлэлийн аудитын тайланд дурдагдсан акт, зөвлөмж, шаардлагын дагуу зөрчил дутагдлыг арилгасан байдлыг нэгтгэн харуулбал:

Дүгнэлт, зөвлөмж, шаардлага ирүүлсэн байгууллага	Зөвлөмж шаардлагын тоо	Зөрчил дутагдлыг арилгах талаар төлөвлөгөө гаргасан байдал	Хэрэгжүүлсэн гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ
Үндэсний Аудитын газар /санхүү/	6	+	95.00	4.75
Нийслэлийн төрийн аудитын газар	4	+	95.00	4.75
Нийт			95.00	4.75

Үндэсний аудитын газраас хүргүүлсэн шаардлагын дагуу гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт:

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлан 2021 он

ҮАГ-аас ТЕГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт гарган, 1 акт, 1 албан шаардлага, 4 зөвлөмж ирүүлснийг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласнаар 95.00 хувь нь хэрэгжсэн байна.

Төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл	Үнэлгээ
Үндэсний аудитын Акт	Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцас хийлгэх гэрээт ажлын төлбөрөөс хэмнэгдсэн 146.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.7-д заасантай тус тус нийцэхгүй байна.	Татварын улсын байцаагчийн дүрэмт хувцас хийлгэх гэрээт ажлын төлбөрөөс хэмнэгдсэн 146.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын төсөвт 2021 оны 06-р сарын 18-ны өдөр шилжүүлсэн.	100.0
Үндэсний аудитын Албан шаардлага	Татварын албаны хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 4'983 мэдээлэл байршуулахаас 386 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба 5.0 сая дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 1,451.0 сая төгрөгийн 85 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар Татварын ерөнхий газрын даргын 01/263, ТЗУГ-ын даргын 03/1334 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд 2021 онд 26.4 тэрбум төгрөгийн орлогын гүйлгээ 22.5 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг сар бүрийн 30 төрлийн маягтын дагуу мэдээлсэн.	90.0
Үндэсний аудитын зөвлөмж	Тайлант онд урсгал зардлын төсвөөс 294.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч бэлтгэсэн байна.	2021 онд 9.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан бөгөөд хяналтыг тухай бүр тавьж зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.	90.0
Үндэсний аудитын зөвлөмж	ТЕГ-ын үндсэн үйл ажиллагааны орлого 4.9 хувь буюу 184.2 сая, туслах үйл ажиллагааны орлого 99.9 хувь буюу 267.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Мөн татварын албаны хэмжээнд 49.7 сая төгрөгийн 166,560 ширхэг ашиглах боломжгүй үнэт цаас бараа материалын дансанд үлдэгдэлтэй байна.	Татварын албаны хэмжээнд Татварын удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлсэнтэй холбоотойгоор бэлэн мөнгөний тасалбар, татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлсөн гэрчилгээ зэрэг борлуулдаг тооцоот маягтууд хүчингүй болсон, туслах үйл ажиллагааны орлого, Ковид-19 цар тахлын үед хатуу хөл хорио тогтоосонтой холбоотой архи тамхины акцын захиалга буурсан зэрэг шалтгаанаар үндсэн үйл ажиллагааны орлогууд тус тус тасарсан. Үнэт цаас тооцоот маягт устгах ажлын хэсгийг А/54 дугаар тушаалаар баталж 06 дугаар сарын 04-ний өдөр Баянзүрх дүүргийн Амгалан дахь Tiger пивоны үйлдвэрийн уурын зуухны газарт устгаж, устгасан тухай тайланг ТЕГ-ын даргад танилцуулсан.	100.0
Үндэсний аудитын зөвлөмж	Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг хуулиар заасан хугацаанд иж бүрэн ирүүлээгүй зөвхөн эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэл нэмэлт санхүүжилтийн тайлбар тодруулгагүй бэлтгэсэн, төсвийн тодруулгын тайланг Сангийн сайдын батлагдсан маягт аргачлалын дагуу гаргаагүй байна.	2021 оны санхүүгийн тайланг гаргахдаа Татварын 32 албаны төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн нэгтгэхээр ажиллаж байна.	90.0
Үндэсний аудитын зөвлөмж	Шинэчлэн батлагдсан татварын багц хуулиудын талаарх сурталчилгаа нэвтрүүлэг, шторк түгээх ажил үйлчилгээний гэрээт ажлын зарцуулалтаас гэрээ дүгнэсэн актгүй 52.3 сая, үр ашиггүй 36 сая төгрөгийн зардал тус тус гаргасан байна.	Гэрээ дүгнэсэн актгүй 5 байгууллагын 5 төрлийн актыг нөхөн гаргуулж санхүүгийн баримтад хавсаргасан бөгөөд цаашид үр ашиггүй зардал гаргахгүйгээр ажиллаж байна.	100.0
ҮАГ-н дүн			95.00

Нийслэлийн төрийн аудитын газраас ирүүлсэн зөвлөмжийн байдал:

НТАГ-ын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 727 дугаар албан бичгээр ирүүлсэн Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд 2018, 2019 оныг хамруулсан нийцлэлийн аудитаар 4 зөвлөмж ирүүлсэн ба тус зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласнаар 2021 оны гүйцэтгэл нь 95.0 хувьтай байна.

Төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл	Үнэлгээ
-------	-------------------------	-----------	---------

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлан 2021 он

НТАГ-ын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 727 дугаар албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит	УБЕГ-тай хамтран ажиллах гэрээнд өөрчлөлт оруулах, албан бичгээр хандах зэргээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нэмэгдсэн, хасагдсан үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөгчийн өөрчлөлт хөдөлгөөний мэдээллийг солилцох асуудлыг шийдвэрлэх	УБЕГ-тай хамтран ажиллах, мэдээлэл солилцох гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар 3 удаагийн уулзалт зохион байгуулан, гэрээний төслийг шинэчлэн боловсруулан батлуулсан. Мөн Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2019 оны гэрээний дагуу Үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг огнооны эрэмбээр авах сервисийг УБЕГ-ын МТТ, Үндэсний дата төвд хөгжүүлэлтийг хийлгэж ТУНС-д хөрвүүлэх ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ГТСМТТ-өөр хийлгэж ажилласан. Мөн УБЕГ-т бүртгэлтэй нийт Үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг ТБМНС-д үүсгэж, үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөгчийн өөрчлөлт хөдөлгөөний мэдээллийг солилцох асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Хөндлөнгийн мэдээлэл лавлагаа цэсийг шинэчлэн ажилласнаар иргэн хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн дугаар, Хаяг, Зориулалт, Талбайн хэмжээ Эрхийн төрөл /өмчлөх, эзэмших, ашиглах/, Өмчлөгчөөр бүртгүүлсэн огноо, Хөрөнгийн төрөл /газар, үл хөдлөх, хөдлөх/ Өмчлөгчөөр бүртгүүлсэн үндэслэл, Өмчлөгчийн тоо зэрэг 9 төрлийн мэдээллийг авах боломжтойгоор нэвтрүүлсэн.	100.0
	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах суурь үнэлгээ болон татвар ногдуулах, чөлөөлөх хөрөнгийг татварын зорилгоор оновчтой тодорхойлох, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд Хууль тогтоомжийн тухай хууль болон ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын дагуу үнэлгээ хийж, судалгаа, танилцуулга бичиж, уг судалгааны дүгнэлтэд үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулах саналыг ТЕГ-ын даргын 2021.12.30-ны өдрийн 01/2905 тоот албан бичгээр СЯ-д хүргүүлсэн.	100.0
	Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдээгүй 9515 үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч бүртэй тулган шалгаж, татварт хамруулах замаар хуулийн хэрэгжилтийг хангуулах, 900 орчим үл хөдлөх хөрөнгөд дутуу болон ногдуулаагүй татварыг нөхөн ногдуулж төлүүлэх	Нийцлийн аудит хийх явцад илэрсэн 9,515 үл хөдлөх эд хөрөнгийг ТУНС-д бүртгэж, 16,517.8 сая төгрөгийн албан татвар ногдуулаагүй зөрчлийг арилгаж үл хөдлөх эд хөрөнгийг тулган шалгаж, татварт хамруулах, нөхөн төлүүлэхэд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд: 1. Нийт 192 үл хөдлөх эд хөрөнгийг ТУНС-д бүртгэж, 0.5 сая төгрөгийн албан татвар ногдуулан төлүүлсэн. 2. Налайх дүүрэгт 32 үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар давхардсан 3. Үл хөдлөх хөрөнгийг өмчлөгч тус бүрээр шалган тулгалт хийхэд Налайх дүүрэгт 110, Баянгол дүүрэгт 68, Чингэлтэй дүүрэгт 65, нийт 243 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байсан ба тэдгээр нь улсын бүртгэлийн “Ү” дугаараар биш татварын бүртгэлийн “Т” дугаараар бүртгэгдсэн байсныг татварын мэдээллийн системд залруулсан 4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлөгдөх хуулийн этгээдийн 18 эд хөрөнгийн бүртгэл ирсэн /Чингэлтэй дүүрэг/ 5. Тухайн хуулийн этгээд, иргэнд үл хөдлөх эд хөрөнгө байхгүй буюу давхардсан Сонгинохайрхан дүүрэгт 7, Баянгол дүүрэгт 52, нийт 59 үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл. 6. Дүүрэг давхардсан 2 үл хөдлөх эд хөрөнгө Багахангай дүүрэг байрладаг “Газ Импорт” ХХК нь Баянзүрх дүүрэгт бүртгэлтэй, “Эрдхул” ХХК нь Сонгинохайрхан дүүрэгт бүртгэлтэй байгаа тул тухайн 2 татвар төлөгчтэй холбогдож бүртгүүлсэн. Нийт 9,515	90.0

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлан 2021 он

		үл хөдлөх эд хөрөнгийг ТУНС-д бүртгэж, татвар ногдуулахаас 546 үл хөдлөх эд хөрөнгийн давхардсан, бүртгэгдсэн зэрэг шалтгааныг тодруулан 0.5 сая төгрөгийн татвар ногдуулж төлүүлэн ажилласан байна.	
	Татварын удирдлагын нэгдсэн шинэ системд татварын байгууллагаас олгосон дугаартай байгаа үл хөдлөх эд хөрөнгө бүрийг улсын бүртгэлийн гэрчилгээний дугаараар шинэчлэн бүртгэх, татварын хувь хэмжээг үндэслэлтэй тогтоосон эсэхийг үл хөдлөх эд хөрөнгө бүрээр хянах, шалгах ажлыг нийслэл, дүүргийн хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулж хэрэгжүүлэх, үр дүнг хянах.	Нийслэл дэх Төрийн аудитын газраас Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар дутуу ногдуулсныг төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авах талаар дүүргийн татварын хэлтсүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн хүрээнд дүүргийн татварын хэлтсүүдэд, хэлтсийн даргын тушаалаар байцагч томилогдон, Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн хөрөнгийг тодорхойлох, татвар ногдуулах, төлөлттэй холбоотой системийн болон шийдэл, зохицуулалтаас шалтгаалсан Тах-act системд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэхдээ улсын бүртгэлийн “Ү” дугаараар бүртгээгүй, үл хөдлөх эд хөрөнгийг өмчилж эхэлсэн, дууссан, шилжүүлсэн огноо, худалдах, худалдан авах гэрээ, хэлцлийн үнэ, хөрөнгийн үнэлгээтэй холбоотой мэдээллийг харах боломжгүй зэрэг асуудлууд байгааг шийдвэрлэхэд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч бүрээр тулгалт хийж, Үл хөдлөх хөрөнгийг өмчлөгч тус бүрээр шалган тулгалт хийхэд Налайх дүүрэгт 110, Баянгол дүүрэгт 68, Чингэлтэй дүүрэгт 65, нийт 243 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байсан ба тэдгээр нь улсын бүртгэлийн “Ү” дугаараар биш татварын бүртгэлийн “Т” дугаараар бүртгэгдсэн байсныг татварын мэдээллийн системд залруулан бүртгэсэн.	90.0
НТАГ-н дүн			95.0

Үнэлгээ: 95.0

2.6 Шилэн дансны хөтлөлт

Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар бүлэгт заасан 29 мэдээллээс шилэн дансны цахим хуудсанд тавигдсан 3 дэд цэсийн 20 мэдээллийг байршуулсан. Татварын албаны хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд тавигдсан 3 дэд цэсийн 20 мэдээллийг оруулсан ч хагас, бүтэн жил, улирал, сарын мэдээнээс хугацаандаа байршуулах 4'983 мэдээллээс сар тутам оруулах 151 мэдээг хугацаа хоцроож оруулсан. Бүтэн жил, улирал тутам оруулах мэдээнээс 15 мэдээг хугацаа хоцроож байршуулсан байна.

**Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ, тайлан илгээсэн байдлыг хугацааны хувьд
Татварын албадаар авч үзвэл:**

№	Албаны нэр	Нийт мэдээлэх мэдээллийн тоо	Хугацаандаа мэдээлсэн мэдээллийн тоо	Хугацаа хоцроож мэдээлсэн мэдээллийн тоо	Мэдээлэл байршуулаагүй	Дүн	Хувь
1.	ТЕГ	151	144	7	0	147.5	97.68
2.	Архангай	151	151	0	0	151	100.00
3.	Баян-өлгий	151	147	4	0	149	98.68
4.	Баянхонгор	151	151	0	0	151	100.00
5.	Булган	151	150	1	0	150.5	99.67
6.	Говь-Алтай	151	126	25	0	138.5	91.72
7.	Говьсүмбэр	151	151	0	0	151	100.00
8.	Дорноговь	151	146	0	5	146	96.69
9.	Дорнод	151	150	1	0	150.5	99.67
10.	Дундговь	151	150	1	0	150.5	99.67
11.	Завхан	151	142	7	2	145.5	96.36
12.	Өвөрхангай	151	140	10	1	145	96.03
13.	Өмнөговь	151	141	9	1	145.5	96.36

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлан 2021 он

14.	Сүхбаатар аймаг	151	148	3	0	149.5	99.01
15.	Сэлэнгэ	151	148	3	0	149.5	99.01
16.	Төв	151	138	8	5	142	94.04
17.	Увс	151	141	4	6	143	94.70
18.	Ховд	151	151	0	0	151	100.00
19.	Хөвсгөл	151	149	1	1	149.5	99.01
20.	Хэнтий	151	151	0	0	151	100.00
21.	Дархан-Уул	151	140	8	3	144	95.36
22.	Орхон	151	151	0	0	151	100.00
23.	УТӨХГ	151	135	16	0	143	94.70
24.	НТГ	151	151	0	0	151	100.00
25.	Хан-Уул	151	142	5	4	144.5	95.70
26.	Баянзүрх	151	150	1	0	150.5	99.67
27.	Сүхбаатар дүүрэг	151	146	4	1	148	98.01
28.	Баянгол	151	151	0	0	151	100.00
29.	Багануур	151	145	5	1	147.5	97.68
30.	Багахангай	151	124	14	13	131	86.75
31.	Налайх	151	129	18	4	138	91.39
32.	Сонгино-хайрхан	151	151	0	0	151	100.00
33.	Чингэлтэй	151	138	11	2	143.5	95.03
Дүн		4'983	4'768	166	49	147.0	97.35

Татварын албаны хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд нийт 3 бүлэг 20 дэд цэсний 151 мэдээ тайлан илгээхээс 33 Татварын албаны хэмжээнд 4'983 мэдээ байршуулахаас 4'768 мэдээ буюу 95.69 хувийг хугацаанд нь байршуулж, 166 мэдээ буюу 3.33 хувийг хугацаа хоцроож илгээсэн бол шилэн дансны мэдээлэлд байршуулаагүй 49 мэдээ буюу 0.98 хувь байна.

Үнэлгээ: 97.35

Гурав. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний тайлан

Монгол Улсын “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралт “Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт”-ийг хангах зорилгоор татварын албаны хэмжээнд төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх ажлын биелэлт, үнэлгээ дараах байдалтай байна. Үүнд:

Д/Д	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо	Үнэлгээ	
			Хувь	Оноо
1	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	9	95.71	4.79
2	Хүний нөөцийн ил тод байдал	5	98.00	4.90
Нийт дүн		14	96.86	4.84

Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн 09 дүгээр хавсралт ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 14 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж ТЕГ хэрэгжүүлдэггүй 2 үзүүлэлтийг үнэлээгүй болно.

Хавсралт-7-р хэрэгжилт хүргүүлэв.

Үнэлгээ: 96.86

Дөрөв. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээг агентлагийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хэрэглэгчийн үнэлгээ гэсэн үндсэн 2 үзүүлэлтээр үнэлэхэд дараах байдалтай байна.

Д/Д	Агентлагийн үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Үнэлгээ	
		Хувь	Оноо
4.1	Агентлагийн үйл ажиллагааны шалгуур	93.70	28.11

4.2	Хэрэглэгчийн үнэлгээний тайлан	90.00	13.50
Үнэлгээний нийт оноо		91.85	41.61

4.1 Агентлагийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт

Д/Д	Агентлагийн үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	Үнэлгээ	
		Хувь	Оноо
1	Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	107.51	30.0
2	Татвар төлөгчийн бүртгэлийн өсөлт, бууралт, татварын суурийг өргөжүүлсэн байдал	133.64	15.0
3	Татварын ногдол, төлөлтийн байдал	71.23	8.75
4	Татварын тайлан хүлээн авалтын түвшин	80.02	14.03
5	Татвар өр хураалтын түвшин	69.64	8.80
6	Татварын хяналт шалгалтын дүн	100.0	9.47
7	Татварын буцаан олголт	100.0	4.0
8	Зуун төгрөгийн татварын орлогод ногдох зардлын хэмжээ	100.0	4.0
Үнэлгээний нийт оноо			94.05

Хавсралт-9

Үнэлгээ:94.05

4.2 Хэрэглэгчийн үнэлгээний тайлан

Татвар төлөгчдийн зан төлөв, сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” ХХК-тай хийсэн гэрээний дагуу гүйцэтгүүлсэн бөгөөд 1932 онд АНУ-ын социологич Ренсис Лайкертын үндслэсэн “Лайкертын шкал-Likert scale” аргыг ашиглан татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон байна.

Судалгааны талаар товч танилцуулбал:

Зорилго

Татвар төлөгчдийн хувьд татварын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэг, зан төлөв, сэтгэл ханамжийн үнэлгээ, тулгамдаж буй асуудлуудын талаарх санаа бодлыг тодорхойлох хүрээнд татвар төлөгчдийн сегмент тус бүрээр:

- Татварын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэг,
- Татвар төлөгчдийн зан төлөв,
- Татварын байгууллагын үйлчилгээ дэх сэтгэл ханамжийн үнэлгээ,
- Тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох замаар цаашид татварын байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай мэдээллийн суурийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Түүвэрлэлт, хамрах хүрээ:

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны түүвэрлэлтийг хийхдээ Татварын ерөнхий газрын тоон мэдээлэлд үндэслэсэн болно. 2021 оны байдлаар улсын хэмжээнд 448,999 татвар төлөгч байна. Үүний 49.1%-ийг нь хувиараа бизнес эрхлэгч иргэд, 42%-ийг бичил сегмент, 8.4%-ийг жижиг сегмент, 0.3%-ийг дунд сегмент, 0.2%-ийг том сегментийн татвар төлөгчид бүрдүүлж байна.

Судалгааны түүвэрт нийт 2242 татвар төлөгч хамрагдсан бөгөөд энэ нь нийт эх олонлог болох 448.9 мянган татвар төлөгчийг 95%-тай төлөөлөх бөгөөд алдааны түвшин 2.0% буюу судалгааны үр дүн +;-2.0%-иар хэлбэлзэж болно.

Зураг 1. Түүврийн тооцоолол

Determine Sample Size

Confidence Level: ☒ 95% ☐ 99%

Confidence Interval:

Population:

Sample size needed:

Судалгаанд хамрагдсан татвар төлөгчдийг харьяа татварын байгууллагаар задлан дараах хүснэгтэд харуулав. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан татвар төлөгчийн харьяа татварын алба, түүврийн хэмжээ, эзлэх хувь

Харьяа татварын алба	Түүврийн хэмжээ	Түүвэрт эзлэх хувь
Том татвар төлөгчийн газар	55	2%
Нийслэлийн татварын газар	29	1.8%
9 дүүргийн татварын алба	634	28%
Архангай аймаг	113	5%
Баян-Өлгий аймаг	69	3%
Баянхонгор аймаг	103	5%
Булган аймаг	118	5%
Говь-Алтай аймаг	97	4%
Говьсүмбэр аймаг	61	3%
Дархан-Уул аймаг	19	1%
Дорноговь аймаг	44	2%
Дорнод аймаг	82	4%
Дундговь аймаг	48	2%
Завхан аймаг	27	1%
Орхон аймаг	54	2%
Өвөрхангай аймаг	38	2%
Өмнөговь аймаг	99	4%
Сүхбаатар аймаг	80	4%
Сэлэнгэ аймаг	66	3%
Төв аймаг	146	7%
Увс аймаг	50	2%
Ховд аймаг	53	2%
Хөвсгөл аймаг	114	5%
Хэнтий аймаг	43	2%
Нийт	2242	100%

Татвар төлөгчдийн боловсрол, сэтгэл ханамжийг тодорхойлох судалгаанд 40% нь жижиг сегментийн татвар төлөгчид, 35% нь дунд сегмент, 22% нь хувь хүн, 2% дунд, 2 том сегментийн татвар төлөгчид хамрагджээ.

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлоход ашигласан аргачлал:

ЛАЙКЕРТЫН ШКАЛ

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг ЛАЙКЕРТЫН ШКАЛ ашиглаж хийж гүйцэтгэсэн. Америкийн нийгмийн сэтгэл зүйч, эрдэмтэн Лайкерът 1932 онд Лайкертын шкал гэж нэрлэгдэх үнэлгээг гаргаж ирсэн ба түүнээс хойш уг үнэлгээний арга зүйг нийгмийн судалгаа, сэтгэл судлалын туршилтад өргөнөөр ашиглах болсон байдаг.

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭГ 1-5 ОНООНЫ СИСТЕМЭЭР ҮНЭЛҮҮЛСЭН.

- 4.50-5.00 буюу 90%-100% байвал үйлчлүүлэгч маш сэтгэл ханамжтай бөгөөд энэ нь бодит нөхцөл байдал дээр тийм ч олон тохиолддоггүй онолын түвшний ойлголт юм.
- 3.50-4.49 буюу 70%-89% байвал үйлчлүүлэгч сэтгэл ханамжтай бөгөөд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага буюу боломжийн гэж үздэг.
- 2.50-3.49 буюу 50%-69% хооронд байх тохиолдолд дунд сэтгэл ханамжтай ба цаашид сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлдэг.
- 1.50-2.49 буюу 30%-49% хооронд үйлчлүүлэгч сэтгэл ханамжгүй байгаа бөгөөд цаашид яаралтай сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлж байгаа юм.
- 1.49-с буюу 29% доош байгаа бол энэ нь үйлчлүүлэгч огт сэтгэл ханамжгүй байгаа бөгөөд маш хангалтгүй байгааг илэрхийлнэ.

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлон цаашид сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлийг тодорхойлоход ашигласан аргачлал:

GAP шинжилгээ

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэх ажлуудыг тодорхойлохдоо GAP шинжилгээ ашигласан. Энэхүү шинжилгээ нь чухалчлах байдал болон сэтгэл ханамжийн түвшний хамаарлаар сэтгэл ханамжийн түвшинд нөлөөлж байна. үзүүлэлтүүдийг сайжруулах, хадгалах, анхаарах, ажиглах гэсэн 4 талбарт ялган хавтгайд байгуулдаг аргачлал юм.

1-р хавтгай нь чухалчлах байдал өндөр ба сэтгэл ханамж бага **ХАМГИЙН ТҮРҮҮНД САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ** үзүүлэлт

2-р хавтгай нь чухалчлах байдал өндөр ба сэтгэл ханамж өндөр үзүүлэлт

3-р хавтгай нь чухалчлах байдал бага ба сэтгэл ханамж харьцангуй өндөр үзүүлэлт

4-р хавтгай нь чухалчлах байдал бага ба сэтгэл ханамж бага үзүүлэлт

Зураг 2. GAP шинжилгээ**ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ**


Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийг дараах 11 бүлгийн 85 үзүүлэлтээр тодорхойлсон байна.

- Бүртгэл, тодорхойлолт, лавлагаа, тоон гарын үсэг олгох үйлчилгээ
- Нэг цэгийн үйлчилгээ
- Татварын улсын байцаагчдын харилцаа, мэдлэг, ур чадвар
- Татвар ногдуулалт, тайлагнах, тайлангаа системд шивэх
- Татвар төлөлт
- Татварын хяналт шалгалт
- Татвар төлөгчдөд зориулсан сургалт
- Лавлах утас 1800-1288
- Албан ёсны сайтууд
- Сошиал сайтууд

- Цахим шилжилт

Албаны хэмжээнд нийт татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшин 71.9% байна. Сэтгэл ханамжийн түвшин 70%-89% хооронд байх тохиолдолд харилцагчид “сэтгэл ханамжтай” бөгөөд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага буюу боломжийн гэж үздэг.


Зураг 3. Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ



Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээнээс харвал том сегментийн татвар төлөгчдийн сэтгэл ханамж хамгийн бага буюу 60%, дунд сегментийн татвар төлөгчид 64%, жижиг сегментийн татвар төлөгчид 69%-ийн сэтгэл ханамжтай байна. Харин бичил сегмент болон хувь хүмүүс 70%-иас дээш сэтгэл ханамжтай байна.

50%-69% хооронд байх тохиолдолд дундаж түвшний сэтгэл ханамжтай ба цаашид сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатай харуулж байгаа юм. Татварын орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлэгч том, дунд, жижиг татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэх тал дээр арга хэмжээ авах шаардлагатай.

Зураг 4. Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, сегментээр



Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дүгнэлт:

Татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг нийт 11 бүлгийн 84 үзүүлэлтийн дунджаар тодорхойлсон. Нийт татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн индекс 72 хувь байна.

Онолын хувьд сэтгэл ханамжийн үнэлгээ “70%-89%” хооронд байх нь сайн гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд харьцангуй санаа зовох зүйл бага, боломжийн түвшинд байна.

Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээг татвар төлөгчдийн сегментээр харьцуулахад Том сегментийн үнэлгээ “60%”, Дунд сегментийн үнэлгээ “64%”, Жижиг сегментийн үнэлгээ “69” байна. Сэтгэл ханамжийн үнэлгээ “50%-69%” хооронд байх нь дунд гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд энэ түвшний үнэлгээ нь цаашид сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлдэг. Цаашид эдгээр сегментийн татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай болох нь уг үр дүнгээс харагдаж байна.

Бичил сегментийн сэтгэл ханамжийн үнэлгээ “72%”, хувь хүмүүсийн сэтгэл ханамжийн үнэлгээ “73%” байна. Сэтгэл ханамжийн үнэлгээ “70%-89%” хооронд байх нь сайн гэсэн утгыг илэрхийлдэг. Уг хоёр сегментийн хувьд бөгөөд харьцангуй санаа зовох зүйл бага, боломжийн түвшинд байна.

Сэтгэл ханамжийн үнэлгээг тодорхойлсон 11 бүлэг үйлчилгээнээс татвар төлөгчдийн хувьд хамгийн чухал нь татвар ногдуулалт, тайлагнах бүлэг байгаа бол 2-рт нэг цэгийн үйлчилгээ, 3-рт татвар төлөгчдөд зориулсан сургалт, 4-рт татварын байцаагчдын харилцаа, ур чадвар зэрэг бүлгүүд жагсаж байна.

Эдгээр 11 бүлгээс хамгийн бага үнэлгээ авсан нь татвар ногдуулалт, тайлагнах үйлчилгээ /69%/ байна. Татвар төлөгчдийн хамгийн их чухалчилж буй уг бүлгийн сэтгэл ханамжийн үнэлгээ бага байгаа нь ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж байна.

БҮЛЭГ	Анхаарах асуудлууд
Бүртгэлийн үйлчилгээ	- Шинээр бүртгүүлэх, - Бүртгэлээс хасуулах, - Бүртгэлдээ нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг үйлчилгээнүүдэд анхаарах - Бүртгэлийн үйлчилгээг цахимаар авах талаарх мэдээллийг хүргэх, цахим системийн хэвийн ажиллагааг хангах
Нэг цэгийн үйлчилгээ	- Нэг цэгийн үйлчилгээний ажилчдын ажилдаа хандах хандлага буюу татвар төлөгчдөд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чин сэтгэлээсээ хандах байдал - Үйлчилгээний түргэн шуурхай байдал - Татвар төлөгчдийг ялгаварлахгүй жигд харьцах /Бичил сегмент болон хувь хүн илүүтэй анхаарах/
ТУБ-дын харилцаа, мэдлэг, ур чадвар	- ТУБ-дын асуудлыг шийдвэрлэх хурд - ТУБ-дын мэдлэг, ур чадвар - Татвар төлөгчидтэй найрсаг, хүндэтгэлтэй харилцах /Бичил сегмент болон хувь хүн илүүтэй анхаарах/
Татвар ногдуулалт, тайлагнах	- Цахим татварын системийн ажиллах хурд, гацалтгүй хэвийн ажиллагаа - Бичил сегмент хувь хүмүүс цахим системийн хэрэглээний талаар мэдээлэл өгч, дадал бий болгох - Бичил сегментийн татвар төлөгч ААН-ийн эзэн болон хувь хүмүүс өөрсдөө татварын тайлангаа гаргах байдал илүү байгаа учир энэ сегментүүдэд уг үйлчилгээтэй холбоотой сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх
Татвар төлөлт	- Татвар төлөх хугацаанд уян хатан хандах байдал - Татвараа хугацаандаа төлж чадаагүй хүндэтгэх шалтгааныг ойлгох байдал - Жижиг, бичил сегмент болон хувь хүмүүст цахим татварын системээр төлбөрийн нэхэмжлэхээ үүсгэх, татвар төлсөн баримтаа цахим системээс авах зэрэг үйлчилгээг таниулах
НӨАТ	- Жижиг, бичил сегмент болон хувь хүмүүс НӨАТ-ын тухай хуулийн талаар мэдээлэл өгөх - НӨАТ төлдөггүй газруудад /Томоохон хүнс, бараа, хувцас, барилгын материал, авто сэлбэгийн худалдааны төвүүд, орон нутгийн дэлгүүр, буудал, онлайн худалдаа, сугалаа, эмийн бөөний төв гэх мэт/ анхаарал хандуулах, НӨАТ төлөгчөөр бүртгэх
Татварын хяналт, шалгалт	- Татвар төлөгчдийг оновчтой сонгож хяналт, шалгалт хийдэг байх /сонгосон шалтгааныг ойлгуулах, тайлбарлах/ - Хяналт шалгалтын ТУБ-дын хуулийн дагуу мэдээлэл, материал шаарддаг байдал - Хяналт шалгалтын ТУБ-дын ёс зүй /Авлига, дарамт, хууль бус шаардлага/ - Хяналт шалгалтаар тавигдсан дүгнэлт, актын үндэслэлтэй байдал, хяналт шалгалтын дараах зөвлөгөө /Том, дунд сегмент/
Татвар төлөгчдөд зориулсан сургалт	- Сургалт зарлаж буй хугацааны тохиромжтой байдал - Сургалтын тоог нэмэгдүүлэх, цахим сургалтыг нэмэгдүүлэх - Сургалт орж буй ТУБ-дын мэдлэг чадвар, сургалтын үр өгөөжтэй байдал /Том, Дунд/
Лавлах утас 1800-1288	- Утсаа түргэн шуурхай авах, хариу өгөх байдал /авч амжаагүй бол эргэж холбогдох/ - ТУБ-дын асуудал шийдвэрлэх хурд - Дуудлагыг бусад дамжуулахгүй байх зэрэгт анхаарах

Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлан 2021 он

Албан ёсны сайтууд болон сошиал хаяг	- Мэдээллээ шинэчлэх давамж - Татварын хууль тогтоомж, дүрэм журмын өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой, шинэлэг мэдээлэл оруулах байдал - Сошиалаар мэдээллийг дамжуулахдаа сонирхолтой видео контент, бичлэг хэлбэрээр бэлтгэж, ойлгомжтойгоор оруулах
Татварын байгууллагын цахим шинэчлэл	- Татварын байгууллагын цахим шилжилтэд татвар төлөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ хамгийн өндөр байна. - Цаашид шинээр бий болгосон цахим үйлчилгээнүүдийн хэрэглээг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээний давуу талуудыг татвар төлөгчдөд ойлгуулахад анхаарах

Үнэлгээ:

Лайкертнн шкалын оноог хяналт шинжилгээ үнэлгээний 100 онооны системд шилжүүлбэл татварын албаны хэрэглэгчийн үнэлгээ **90.00** оноогоор үнэлэгдэж байна.

Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар хүргүүлэв.

Тайлантай холбоотой тодруулах зүйл гарвал:

ТЕГ-ын Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний газрын 314155, 311139 дугаарын утсаар холбогдоно уу.

-ooOoo-